

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/123/СТА-ТШЗ

Баянхонгор хот. 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424      Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345      Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал .....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/24  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн

2519022

бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Ч.Баярсайханд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.23-наас 2019.02.23–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б. Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг нь "Хүүхдэд томчууд тусалж аливааг хамтран хийнэ. Маргааш-Хүүхэд өөрөө бие даан сурна" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 46 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous 4.01, цалингийн Payroll" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 305097,9 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 6101,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	6	4.10	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	0.20	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	7	4.30	

### **2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Санхүүгийн тайланд 2018 онд олгосон цалингийн зардлыг 2327431 төгрөгөөр илүү, мөн дүнгээр НДШ-ийн зардлыг дутуу илэрхийлсэн зөрчлийг санхүүгийн тайланд залруулав.

### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Цалинг программаар бодоогүй, цалингийн цэстийг 1 сард олон удаа тус тусад нь бодсон, зарим ажилтны цалинг гар олгох дүнд шууд нэмж олгосон, ХХОАТ-ын болон 1 сард дутуу авсан 1%-ийн НДШ-ийн тооцооллыг хийхдээ буруу хийсэн зэрэг зөрчилтэй тул хувь хүний орлогын албан татварын тооцооллыг дахин тулгах шаардлагатай.

### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 285319,0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 284077,0 мянган төгрөг буюу 99,6 хувьтай байгаа нь цэвэр бохир усны зардал, шуудан холбооны зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Өөрийн орлогын төлөвлөгөө байхгүй.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

2018 оны эхний 9 сарын шилэн дансны мэдээллийг нийцлийн аудитаар үзсэн тул 10-12 сарын мэдээллийг шалгахад 5 дугаар сарын шийдвэрийг 12 сард мэдээлсэн, 12 дугаар сарын санхүүжилтийг 1343,5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан дансны зааврын дагуу ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулж бүртгэж байх” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 2018 онд 3438349 төгрөгийн 5 гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй, шууд зардлаар тайлагнаж, зөрчил давтагдсан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **2.8.1 ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨӨС БУСАД ХЭЛБЭРЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

##### **2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал**

Нягтлан бодогч Г.Баатар 2018.02.08-наас ажилд орсон байхад цалинг бүтэн олгож, 37062 төгрөгийн цалинг илүү олгосон бөгөөд 2018 оны 05 дугаар сард цалингийн цэстээр олговол зохих цалингаас 30605 төгрөгийг илүү олгосон байна.

Хувь хүний орлогын албан татварын тооцоолол зөрүүтэй, 2-р улиралд олгосон 1928001 төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалингаас 171592 төгрөгийн ХХОАТ суутган тооцоогүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоов.

### 3.1 Зардлын данстай холбоотой асуудал

#### 3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд олгосон цалинг Нийгмийн даатгалын хэлтэст 79213 төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн, 1-р сард Ч.Баярсайханд олгосон цалингийн 106685, 2-р сард Н.Сосорбарамд олгосон 56346 төгрөгийн цалинг НДХ-т мэдээлээгүй, гарт олгох дүнг цалингийн цэстэд оруулж олгосон. Даатгуулагчийн цалинг тухайн сард зөв мэдээлээгүйгээс даатгуулагчаас суутгасан НДШ-ийг 16122 төгрөгөөр зөрүүтэй мэдээлж, түүнийг байгууллагаас төлсөн.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

#### 3.1.2 Эрсдэл:

Цалингийн суутгал хууль журамд нийцэхгүй байх

#### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

**Цалингийн Payroll программыг ашиглан цалинг үнэн зөв бодож, холбогдох суутгалыг хуулийн дагуу суутгаж, НДХ-т тухай бүр цалинг үнэн зөв мэдээлэх**

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

### 3.2 Зардлын данстай холбоотой асуудал

#### 3.2.1 Илрүүлэлт:

Өмнөх оны аудитаар зардлыг тооцооны дансаар дамжуулж байх зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлэлгүй, тайлант онд зөрчлийг дахин давтаж, 3438349 төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардлаар тайлагнасан.

Энэ нь Үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан заавар тус тус зөрчсөн байна.

#### 3.2.2 Эрсдэл:

Зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй байх

#### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

**Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан дансны зааврын дагуу ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулж байх, аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж байх**

#### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

### 3.3 Зардлын данстай холбоотой асуудал

#### 3.3.1 Илрүүлэлт:

Оны эцэст хийсэн тооллогын бүртгэлтэй үндсэн хөрөнгө, бараа материалын тодруулгын тайлангийн дүнтэй тулгахад машин тоног төхөөрөмж, бусад хангамжийн

материалын тооллогын бүртгэл дүнтэй тохирохгүй байна. Энэ нь тооллогын бүртгэлийн нийт дүнг буруу гаргасан, нягтлан бодогч тооллогын бүртгэлд үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүйтэй холбоотой байна.

Энэ нь Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг зөрчсөн байна.

### 3.3.2 Эрсдэл:

Тооллого, тооцоог чанаргүй гүйцэтгэх

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

**Тооллогын комиссын бүрэлдэхүүнд нярав, нягтлан бодогчийг оруулахгүй байх, тооллогыг чанартай гүйцэтгэж буй эсэх, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан маягтуудыг бүрэн хөтөлж буй эсэхэд удирдлагаас тавих хяналтыг сайжруулах**

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

## 3.4 Зардлын данстай холбоотой асуудал

### 3.4.1 Илрүүлэлт:

Завсрын аудитаар бараа материалын эхний үлдэгдэлд хасах тэмдэгтэй хөрөнгө бүртгэлтэй байсныг залруулах зөвлөмж өгсөн байхад оны эцэст хэрэгжүүлээгүй, бараа материалын дэлгэрэнгүй тайлангаар авч үзэхэд 288,3 мянган төгрөгийн бараа материал хасах тэмдэгтэй бүртгэгдсэн байна.

Энэ нь Үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг зөрчсөн байна.

### 3.4.2 Эрсдэл:

Авлага, бараа материалыг буруу ангилан бүртгэсэн байх

### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

**Санхүүгийн программд анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээг зөв зардлаар бүртгэж байх**

### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

## 3.5 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

### 3.5.1 Илрүүлэлт:

Завсрын аудитаар бараа материалыг бөөн дүнгээр бичсэн зөрчилд өмнөх ажилтнуудаас тодруулж, оны эцсийн тайланд материалыг хөрөнгө тус бүрээр задалж бүртгэх зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг зөрчсөн байна.

### 3.5.2 Эрсдэл:

Өмнөх аудитын зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй байх

### 3.5.3 Өгсөн зөвлөмж:

**Санхүүгийн программд өмнөх жилүүдэд бөөн дүнгээр бүртгэсэн материалыг материал тус бүрээр задалж, хөрөнгөд бүртгэх**

### 3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

### 3.6.1 Илрүүлэлт:

2018 оны 12 дугаар сард кассаар 236000 төгрөгийг олгосон атлаа кассын тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан заавар, 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан журмын 7.2 дахь заалт, 2017 оны 347 тоот тушаал тус тус зөрчсөн байна.

### 3.6.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг бүртгэх

### 3.6.3 Өгсөн зөвлөмж:

**Анхан шатны баримтыг үндэслэн санхүүгийн тайланд зөв бүртгэж, Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан журмын 7.2 дахь заалт, 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан НХМаягт МХ4 хавсралтаар батлагдсан бэлэн мөнгөний гүйлгээний тайланг бэлтгэж байх**

### 3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

### 3.7.1. Илрүүлэлт:

3

### 3.7.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 дахь заалтыг хэрэгжүүлж, Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн санхүүгийн тайланд залруулга хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>47,254,345.45</u></b>	<b><u>46,867,266.45</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	47,254,345.45	46,867,266.45
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	10,176,418.40	10,176,418.40
35110	Тусгай зориулалттай материал	10,176,418.40	10,176,418.40
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	36,917,927.05	36,530,848.05
35410	Бичиг хэргийн материал	349,900.00	616,900.00
35420	Аж ахуйн материал	2,260,400.00	2,533,250.00
35450	Барилгын засварын материал	893,300.00	832,100.00
35460	Хүнсний материал	1,911,212.00	1,857,072.00
35470	Бусад хангамжийн материал	31,503,115.05	30,691,526.05
35600	Мал амьтад	160,000.00	160,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>314,622,010.37</u></b>	<b><u>721,722,435.67</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	314,622,010.37	721,722,435.67
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	314,622,010.37	577,772,435.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	559,049,994.00	563,380,074.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-267,976,465.49	-1,307,333.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,013,382.64	41,493,382.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,641,516.91	-36,141,259.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,606,001.12	24,606,001.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,186,172.88	-14,950,117.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,946,016.00	5,946,016.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,451,349.11	-5,563,349.07
39217	Ном	262,121.00	309,021.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	143,950,000.00
39301	Програм хангамж	425,000.00	425,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-425,000.00	-425,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	143,950,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>361,876,355.82</u></b>	<b><u>768,589,702.12</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>361,876,355.82</u></b>	<b><u>768,589,702.12</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	361,876,355.82	768,589,702.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	183,221,843.00	327,171,843.00
51101	Өмч: - төрийн	183,221,843.00	327,171,843.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-64,809,147.18	-24,603,823.94
51210	Өмнөх үеийн үр дүн	-64,809,147.18	-64,809,147.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	40,205,323.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	243,463,660.00	466,021,683.06
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>361,876,355.82</u></b>	<b><u>768,589,702.12</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>310,362,052.80</b>	<b>345,303,213.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,675,957.00</b>	<b>55,202,278.80</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,675,957.00	55,202,278.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,675,957.00	55,202,278.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,675,957.00	55,202,278.80
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,741,895.80</b>	<b>4,781,934.20</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,944,200.00	285,319,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,279,862.80	1,343,585.20
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,279,862.80	1,343,585.20
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>	5,658,000.00	00.00
133003	Хөрөнгийн	5,658,000.00	00.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,804,033.00	3,438,349.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,804,033.00	3,438,349.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>322,649,257.41</b>	<b>305,097,889.76</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>322,649,257.41</b>	<b>305,097,889.76</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	307,963,560.39	278,794,663.34
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	150,289,578.00	147,013,317.88
210101	Үндсэн цалин	134,175,870.00	125,973,839.68
210102	Нэмэгдэл	4,998,508.00	15,824,552.20
210104	Урамшуулал	11,115,200.00	5,214,926.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16,669,800.00	17,990,710.90
210201	Тэтгэврийн даатгал	16,669,800.00	13,800,298.30
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,159,804.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	285,525.04
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,745,083.40
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,103,446.98	43,020,733.00
210301	Гэрэл, цахилгаан	3,632,464.00	3,335,495.00
210302	Түлш, халаалт	28,623,633.00	32,164,052.00
210303	Цэвэр, бохир ус	2,847,349.98	7,521,186.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,004,811.00	6,040,155.00
210401	Бичиг хэрэг	79,000.00	581,100.00
210402	Тээвэр, шатахуун	290,000.00	289,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	655,711.00	704,916.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	980,100.00	961,450.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	3,502,789.00
2105	<b>Нормативт зардал</b>	41,064,323.00	43,548,970.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,000.00	53,100.00
210502	Хоол, хүнс	40,987,323.00	42,489,070.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,006,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	37,586,550.00	2,206,017.00
210604	Урсгал засвар	37,586,550.00	2,206,017.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	80,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	00.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	531,500.00	576,000.00

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	531,500.00	576,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	24,633,551.41	18,398,759.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,811,862.80	422,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	115,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,706,688.61	17,976,759.56
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	14,685,697.02	26,303,226.42
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,100,433.00	25,061,249.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,804,033.00	3,438,349.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	608,500.00	4,986,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,962,900.00	16,333,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,725,000.00	303,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	585,264.02	1,241,977.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	585,264.02	1,241,977.42
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-12,287,204.61</b>	<b>40,205,323.24</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-12,287,204.61</b>	<b>40,205,323.24</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>302,028,095.80</b>	<b>290,100,934.20</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>302,028,095.80</b>	<b>290,100,934.20</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,944,200.00	285,319,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,279,862.80</b>	<b>1,343,585.20</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,279,862.80	1,343,585.20
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,804,033.00</b>	<b>3,438,349.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,804,033.00	3,438,349.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>302,028,095.80</b>	<b>290,100,934.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>302,028,095.80</b>	<b>290,100,934.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>287,342,398.78</b>	<b>263,797,707.78</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>150,289,578.00</b>	<b>145,863,943.58</b>
210101	Үндсэн цалин	134,128,878.00	131,994,343.58
210102	Нэмэгдэл	5,045,500.00	5,045,500.00
210104	Урамшуулал	11,115,200.00	8,824,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,669,800.00</b>	<b>17,796,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,669,800.00	17,796,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,103,446.98</b>	<b>43,020,733.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,844,283.00	3,335,495.00
210302	Түлш, халаалт	28,623,633.00	32,164,052.00
210303	Цэвэр, бохир ус	3,635,530.98	7,521,186.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,825,711.00</b>	<b>4,016,716.00</b>
210401	Бичиг хэрэг	85,500.00	689,700.00
210402	Тээвэр, шатахуун	290,000.00	289,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	556,711.00	704,916.00
210404	Ном, хэвлэл	00.00	106,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	893,500.00	2,225,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>39,499,950.00</b>	<b>44,962,330.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,000.00	53,100.00
210502	Хоол, хүнс	39,459,950.00	42,427,430.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,481,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>38,246,550.00</b>	<b>5,206,000.00</b>
210602	Тавилга	660,000.00	00.00
210604	Урсгал засвар	37,586,550.00	5,206,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>80,000.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	80,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>531,500.00</b>	<b>626,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	531,500.00	507,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	118,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,095,862.80</b>	<b>2,305,485.20</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,980,862.80	2,213,585.20

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	115,000.00	91,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,685,697.02</b>	<b>26,303,226.42</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,100,433.00</b>	<b>25,061,249.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,804,033.00	3,438,349.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	608,500.00	4,986,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,962,900.00	16,333,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,725,000.00	303,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>585,264.02</b>	<b>1,241,977.42</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	585,264.02	1,241,977.42

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	183,221,843.00	243,463,660.00	-47,344,298.64	379,341,204.36
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>183,221,843.00</b>	<b>243,463,660.00</b>	<b>-47,344,298.64</b>	379,341,204.36
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	35,954,125.71	35,954,125.71
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>183,221,843.00</b>	<b>243,463,660.00</b>	<b>-64,809,147.18</b>	361,876,355.82
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>183,221,843.00</b>	<b>243,463,660.00</b>	<b>-64,809,147.18</b>	361,876,355.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	222,558,023.06	00.00	222,558,023.06
Тайлант үеийн үр дүн	143,950,000.00	00.00	40,205,323.24	184,155,323.24
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>327,171,843.00</b>	<b>466,021,683.06</b>	<b>-24,603,823.94</b>	768,589,702.12

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	296,944,200.00	296,358,935.98	285,319,000.00	284,077,022.58
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	296,944,200.00	296,358,935.98	285,319,000.00	284,077,022.58
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	284,345,800.00	284,062,535.00	263,686,000.00	262,454,122.58
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	150,289,600.00	150,289,578.00	145,864,000.00	145,863,943.58
210101	Үндсэн цалин	134,128,900.00	134,128,878.00	131,994,400.00	131,994,343.58
210102	Нэмэгдэл	5,045,500.00	5,045,500.00	5,045,500.00	5,045,500.00
210104	Урамшуулал	11,115,200.00	11,115,200.00	8,824,100.00	8,824,100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16,669,800.00	16,669,800.00	17,796,500.00	17,796,500.00
210201	Тэтгэврийн даатгал	16,669,800.00	16,669,800.00	17,796,500.00	17,796,500.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,228,900.00	35,103,446.00	44,020,800.00	43,020,733.00
210301	Гэрэл, цахилгаан	2,849,200.00	2,844,283.00	2,732,400.00	3,335,495.00
210302	Түлш, халаалт	28,623,600.00	28,623,633.00	32,254,700.00	32,164,052.00
210303	Цэвэр, бохир ус	3,756,100.00	3,635,530.00	9,033,700.00	7,521,186.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,837,400.00	1,825,711.00	4,139,200.00	4,016,716.00
210401	Бичиг хэрэг	85,500.00	85,500.00	344,600.00	689,700.00
210402	Тээвэр, шатахуун	290,000.00	290,000.00	290,000.00	289,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	556,800.00	556,711.00	1,172,400.00	704,916.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	56,900.00	106,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	905,100.00	893,500.00	2,275,300.00	2,225,800.00
2105	<b>Нормативт зардал</b>	39,592,000.00	39,499,950.00	44,965,400.00	44,962,330.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,000.00	40,000.00	53,100.00	53,100.00
210502	Хоол, хүнс	39,552,000.00	39,459,950.00	42,427,500.00	42,427,430.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	2,484,800.00	2,481,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	37,586,600.00	37,586,550.00	5,206,000.00	5,206,000.00
210604	Урсгал засвар	37,586,600.00	37,586,550.00	5,206,000.00	5,206,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	80,000.00	80,000.00	106,100.00	00.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	80,000.00	106,100.00	00.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	557,700.00	531,500.00	626,000.00	626,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	557,700.00	531,500.00	507,700.00	507,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	118,300.00	118,300.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1843800.00	1816000.00	962000.00	961900.00

**Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,728,800.00	1,701,000.00	870,000.00	870,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	115,000.00	115,000.00	92,000.00	91,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	12598400.00	12296400.00	21633000.00	21622900.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	12,598,400.00	12,296,400.00	21,633,000.00	21,622,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	608,500.00	608,500.00	4,986,000.00	4,986,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,962,900.00	5,962,900.00	16,333,300.00	16,333,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,027,000.00	5,725,000.00	313,700.00	303,600.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	296,944,200.00	296,358,935.98	285,319,000.00	284,077,022.58
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	296,944,200.00	296,358,935.98	285,319,000.00	284,077,022.58
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,944,200.00	296,358,935.98	285,319,000.00	284,077,022.58
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	20.00	20.00	20.00	20.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	09.00	09.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	152.00	152.00	152.00	152.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	152.00	152.00	00.00	00.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	152.00	152.00	152.00	152.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	152.00	152.00	152.00	152.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>20.00</b>	<b>20.00</b>	<b>20.00</b>	<b>20.00</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	10.00	10.00	10.00	10.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	10.00	10.00